



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр


Дугаар А/381

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны төсөвт батлах тухай тогтоолын 2 дугаар хавсралтын 3.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Улсын бүртгэлийн хэлтэс, архив, Гадаадын иргэн харьяатын газрын Баруун бүс дэх газрын албан конторын барилгын газрын байршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор инженер хайгуулын судлагааны ажил зориулан 5,000,000 төгрөгийг зарцуулсугай.
- 2. Дээрх төсөл арга хэмжээг Орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 3.4-д тусгагдсан "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх" арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.
- 3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ